

Тайлбар

Хууль тогтоох үйл ажиллагааны явцад хуулийн төсөл боловсруулах, хуулийн төслийг УИХ-ын байнгын хороо болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэгтэй ажлын хэсгүүд байгуулдаг. Түүнчлэн тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг байгуулж, ажиллуулдаг.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн арвандөрөвдүгээр бүлгийн 129.1-т “Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсэг, нам, эвслийн бүлгийн хуралдааны тэмдэглэлийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгална” гэж заасан байдаг. Мөн тус хуулийн арвандөрөвдүгээр бүлгийн 130.2-т “Хуралдааны тэмдэглэлийг УИХ-ын албан ёсны цахим хуудсанд байршуулж олон нийт танилцах бололцоог хангана” гэж заасан.

Харамсалтай нь, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл ил тод, нээлттэй бус байна. Иргэдийн мэдэх эрхийг хүндэтгэж, нээлттэй, ил тод байдлыг шаардаж байна.

